

ЦАХИМ ЭРХИЙН АСУУДАЛ БА ТАШАА ХУДАЛ МЭДЭЭЛЛИЙН ДАЛД УРШИГ

Ц. Батцэрэн

Доктор (Ph. D.), профессор

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

Э. Энхцолмон

Магистр

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

Хураангуй: ХХ зууны эхээр хүний эрхийн асуудал дэлхийн өнцөг буланд хурцаар хөндөгдөж эхэлсэн билээ. Харин ХХI зуун гарсаар интернетийн хурцаттай хөгжил буюу AI хүн төрлөхтөнд “Шинэ орчин”-ыг бий болгож амьдралын хүрээ өргөжин тэлж, амьдралын үнэт зүйлст өөрчлөлт орж байна. Үүнтэй холбоотой цахим орчин дох хүний эрх энэ зууны тойрч үл болох асуудал болж байна. Ялангуяа цахим орчны хязгааргүй мэдээлэл, бидний амьдралд хаалга тогшихгүй, хянах боломжгүйгээр нэвтрэн орж байгаа нь анхаарахгүй байхын аргагүй билээ. Цахим орчны худал буюу ташаа мэдээлэл нь бидний эрхийг хэрхэн зөрчиж байна вэ? энэ нь хэнд ашигтай, ямар зорилготой, ямар үр дагавартай гэдэгт энэ итгэлийн агуулгыг чиглүүлсэн болно. Энэхүү агуулгын хүрээнд хүний эрхтэй холбоотой философийн онолд тулгуурлан мэдээллийг авагч болон өгөгч талуудын эрх, үүргийн хамаарал, худал ташаа мэдээллээс үүдэлтэй хүний эрхийн зөрчлийг олон улсын эрх зүйд хэрхэн зохицуулж буй туршлага ба Монгол улсад хэрхэн зохицуулж буй, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар авч үзсэн. Уг судалгаандаа фактор анализ, харьцуулалтын аргуудыг ашигласан болно.

Түлхүүр үг: Хүний эрх, цахим орчин, худал, ташаа, мэдээлэл, зөрчил, ашиг хүртэгч, хор уршиг

УДИРТГАЛ

ХХI зуун гарсаар цахим технологи үсрэнгүй хөгжсөөр, үүнд томоохон нөлөөлсөн зүйлийн нэг нь дэлхийн нийтийг хамарсан Ковид цар тахал байв. Олон улс оронд хөл хорио тогтоосноор бид бүхний өдөр тутмын ажил амьдралыг цахим орчин хангах болсон. Цахим технологи хөгжихийн хирээр түүнийг тойрсон “Хүн” төвт олон асуудлууд ар араасаа гарч байна. Нийгэмд хүний эрхийн асуудал бидний үргэлжийн дуусашгүй сэдэв

байсан бол хил хязгаар, орон зай, цаг хязгааргүйд үргэлжлэх цахим орчинд бидний эрх хэрхэн хангагдаж байна вэ?, Бид бусдын эрхийг санаатай болон санамсаргүйгээр зөрчиж байна уу?, Хэрвээ зөрчигдсөн гэж үзвэл асуудлыг хэрхэн шийдвэрлүүлэх вэ? Хэн хариуцлага хүлээх вэ? Хариуцлагын хэм хэмжээ, зарчим шалгуур ямар байх вэ? гээд маш олон асуудалтай тулгарч байна. Жишээлбэл, бидний мэдээлэл E-mongolia, бусад төрийн

үйлчилгээний байгууллага, банк санхүүгийн байгууллагуудад хангалттай өгөгдөлтэй байна. Би үүнийг хүсэх, эс хүсэхээс үл хамааран, үүлэн систем (iCloud) бидний амьдралын мөч бүрийг мөшгисөөр байгаа билээ. Хүн бол “био социаль” шинжтэй амьтан гэдэг тодорхойлолт өнөө цагт “БИО СОЦИАЛЬ+ЦАХИМ” амьтан гэхэд хүрээд байна.

Цахим орчин гэдэг нь мэдээллийг бий болгож, хуваалцаж, ашигладаг онлайн орон зай, платформыг хэлнэ. Цахим орчин нь хүнд интернэт холболттой хаанаас ч асар их хэмжээний өгөгдөлөөс мэдээллийг хүртээмжтэй олон эх сурвалжаас олж авах, бусадтай интерактив байдлаар харилцаж сэтгэгдэл бичих, лайк дарах, үзэл бодлоо хуваалцах, туршлага солилцох, суралцах, сонирголоороо нэгдэх, дэлхийн зах зээлээс бүтээгдэхүүн үйлчилгээг чөлөөтэй сонгох, соёлын харилцаанд оролцох зэрэг боломжуудыг олгож байгаагаараа хүний эрхийн хүрээг тэлж байна. Цахим орчин нийгмийн залшгүй нэг хэсэг хэдий ч, аналог ертөнц шиг харагдаж, үзэгдэж, бодиттойгоор хянахад хүндрэлтэй. Иймд цахим орчинд хүн эрхээ хэрхэн хамгаалах, бусдын эрхийг хэрхэн хангах вэ? гэдэг орчин цагийн чухал сэдвүүдийн нэг болсон.

Цахим эрх (digital right) гэдэг нь хувь хүн интернетэд хандах, ашиглах, хянах үйл явцтай холбоотой эрх зүйн болон ёс

суртахууны зарчмуудыг хэлдэг. Үүнд мэдээллийг ашиглах хамгаалах, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн хүртээмж тэгш байдал, өмч хийгээд оюуны өмч, интернет дэх бүх өгөгдлийг ялгаварлан гадуурхахгүйгээр ижил байдлаар авах зэрэг эрхүүдийг хөндөж байна. Цахим орчинтой холбоотой хүний эрхийн тэгш байдал, аюулгүй байдал, засаглал, хяналт, хариуцлагын асуудал хэлэлцүүлэгийн сэдэв болохоос гадна мэдээллийн үнэн, худлыг олж илрүүлэн, хянах боломжгүй байна. Иймээс “*Хэн нэгэн нь бусдын зорилгоо биелүүлэх арга хэрэгсэл*” болох боломжтой юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Либеритари үзлээр хүн бүр цахим орчноос мэдээлэл авах, бусдад мэдээлэл түгээх адил тэгш эрхтэй. Тухайн хувь хүн хэн нэгний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төрд халдахаас бусад бүх тохиолдолд бүрэн эрхтэй чөлөөтэйгээр үзэл бодлоо илэрхийлж, үзэл бодол, сонирхол хоббигоороо эвлэлдэн нэгдэх, эдийн засаг, бизнес санхүүгээ өргөжүүлэх зэрэг бүрэн эрхтэй. Гэвч цахим дахь эцэс төгсгөлгүй мэдээ, мэдээлэл нь хувь хүн болон нийгэмд эерэг болон сөрөг нөлөөг үзүүлдэг. Эерэг буюу үнэн зөв мэдээлэлд үндэслэн бид одоо болон ирээдүйд болох нөхцөл байдлыг дүгнэн өөрт ашиг тустай сонголт, шийдвэрийг гаргаж амьдралаа илүү чанартай, сэтгэл хангалуун болгож

болох юм. Худал ташаа мэдээлэл (misinformation vs disinformation, incorrect information) гэдэг нь үйлдлийг хэлбэржүүлж болох төөрөгдүүлсэн мэдээллийг хэлдэг. Энэ нь ихэвчлэн хурдан тархаж, хүмүүсийн шийдвэр, бодит байдлын талаарх ойлголтод нөлөөлдөг. Худал, ташаа мэдээлэл нь янз бүрийн оролцогчдод ашиг тусаа өгөх бөгөөд ихэнхдээ олон нийтийн итгэл, хувь хүний сайн сайхан байдлыг алдагдуулдаг.

Германы философич Артур Шопенхауэрын “Хүн юу хүссэнээ хийж чадна, харин тэр хүссэнээ хүсч чадахгүй” гэсэн алдарт үг байдаг. Бид юу хүсэхээ хүсэж чадах уу? Хүсэл бол бидний эзэн харин бидний ойлгоц бол хүслийн боол нь. Бидний хүсэл үнэндээ ямар шийдвэрийг ил болон далд гаргаж буйг бид тэр бүр ойлгодоггүй, өөрөөр хэлбэл ойлгохоосоо өмнө хүсдэг. Нэгэнт ойлгоцыг оруулахгүй хүсэл дангаар шийдвэр гаргадаг тул бид аливаа хүслийнхээ учир шалтгааныг таамаглах ч үгүй. Энэ санааг Австрийн сэтгэл мэдрэлийн эмч, сэтгэл судлаач Зигмунд Фройд “Психо-анализ” онолдох “Ид”-ээр дамжуулан илүү прагматик тайлбарыг хийсэн билээ. Ид нь хүний төрлөх шинж хүсэл хийгээд биологийн хэрэгцээг тодорхойлно. Ид бол тааламжийн зарчимтай харилцан үйлчилж зөн билэгт ухамсаргүйн хүслийг эрэлхийлнэ. Бид цахим орчны мэдээлэлд ухамсартай үүрэгтэй гэдгээ мэдэх хэдий ч, ирж буй бүх

мэдээлэлд цензуртай хандаж чадах уу? Мэдээллийн агуулга, ач холбогдол, үнэн гэдэгт хяналттай хандахаас илүүтэй, мэдрэмж рүү чиглэсэн дуу дүрс, сенсаац бүхий зүйлд татагдан сонирхож, донтох хандлагатай. Компатибилизм (Compatibilism) -ээр үзэхэд хүн бүр цахим орчны мэдээллийг авах, мэдээлэлд итгэх эсэх нь чөлөөтэй хэдий ч, ёс зүй, эрх зүйн хариуцлагаас мултарна гэсэн үг биш юм.

Цахим орчин дахь худал ташаа мэдээллийн үр дагвар

Технологийн дэвшил нь холыг ойртуулж, цаг хугацааг хэмнэж, мэдээллийг хүн бүрт нээлттэй болгож, бидний үндсэн эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх зэрэг олон эерэг зүйлийг авчирдаг ч үүнтэй зэрэгцэн буруу худал ташаа мэдээлэл тарсанаар цахим орчинд гадуурхал, үзэн ядалт, эрүүл мэнд, аюулгүй байдал гэх мэт олон сөрөг зүйлүүдийг дагуулах боллоо. Сөрөг ташаа мэдээлэлд ашигтай тал байдаг төдийгүй зорилго бүхий субъектуудад давуу тал олгохын сацуу хуурамч мэдээллээс ашиг авч, өөрсдийн хүслийг биелүүлдэг хэсэг субъектууд байдаг. Үүнд:

1. Цахим платформууд: Иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ханах замаар тэдэнд таалагдах, бодлоо хуваалцах, сэтгэгдэл бичих зэрэг боломжийг нээлттэйгээр хангаж өгөх зэргээр хэрэглэгчдийнхээ тоог нэмэх,

тэднийг иэдвхжүүлэх, өөрсдийнхөө хандалтыг ихэсгэдэг. Платформ дахь хандалтын тоо нэмэгдсэнээр тухайн платформуор цацагдах сурталчилгаа нэмэгдэж орлого өсөх бөгөөд ингэхдээ батлагдаагүй, эх сурвалж тодорхойгүй худал ташаа мэдээллийг байршуулж түгээх ажлыг хийж үүндээ хуурамч аккаунт ашиглах, шуугиан тарьсан мэдээллийг дахин эргэлтэнд оруулж түгээх зэрэг үйлдлийг давтамжтайгаар хийдэг.

2. Бизнесийн байгууллагууд: Зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагууд цахим платформуудыг ашиглан бүтээгдэхүүнийхээ зах зээлийг тэлэх, үйлчлүүлэгчдийг татах, өрсөлдөгч байгууллага, компаниудын нэр төрийг унагаах, өөрсөдөө таатай зах зээлийг бий болгох зорилготойгоор худал ташаа мэдээлэл тараах тохиолдолууд байдаг.

3. Хэвлэл мэдээлэл: Мэдээллийн хэрэгслийн байгууллагууд болон сэтгүүлчид хүний эрхийг зөрчиж цахим орчинд олны анхаарлыг татах зорилготойгоор худал ташаа мэдээлэл түгээх нь ихэссэн. Өөрсдийн мэдээллийн сайтын хандалтыг ихэсгэж, ингэснээр сурталчилгааны орлогыг нэмэгдүүлэх зорилготойгоор мэдээллийн үнэн зөвийг нягтлахаас илүүтэйгээр олны анхаарлыг татсан сенсаци бүхий батлагдаагүй худал ташаа мэдээллийг тарааж, бусдын цахим орчин дахь халдашгүй

байдлыг зөрчих, тэдний нэр төрд халдах байдал эрс нэмэгдсэн.

4. Сонирхлын бүлгүүд: Нийгэмд дэх зарим сонирхлын зөрчилтэй бүлгүүд өөрсдийн тодорхой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготойгоор эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, байгаль дэлхий экосистем, нийгэмд тулгамдаж буй асуудлуудыг ашиглан хуурамч мэдээлэл тараан нийгмийн хэсэг бүлэг хүмүүсийн уур бухимдал, айдасыг төрүүлэн өөрсдийн зорилгоо биелүүлэх явдал байдаг. Жишээ нь вакцилны талаарх сөрөг мэдээлэл.

5. Гэмт хэрэгтэнгүүд:

а. Залилан мэхлэх: Цахим платформуудыг ашиглан хүмүүсийн итгэл дээр тулгуурлан худал хуурмаг мэдээ мэдээлэл тараах замаар гэмт хэрэгтэнгүүд эрх зүйн мэдлэг бага болон өндөр настан хүмүүсийг залилах тохиолдол их байдаг.

б. Цахим дээрлхэлт (cyber bullying): Хуурамч аккаунт хаягаар дамжуулан насанд хүрээгүй хүүхдүүдтэй онлайнаар танилцан итгэлийг нь олох замаар тэдний зураг бичлэгийг авч бусдад тарааж дэлгэрүүлэх зорилготойгоор гэмт хэргийн золиос болгох замаар цахим дээрлхэлт сүүлийн үед дэлхий дахинаа хүчээ авах болсон.

6. Улс төрийн байгууллагууд: Сонгуулийн манипуляци хийх зорилготойгоор улс төрийн нам, байгууллагууд, улс төрд нэр дэвшигчид цахим орчинд бусдын эрхэнд халдаж хуурамч мэдээлэл

түгээх, өрсөдөгчийн нэр төрд халдах, олон нийтийн санаа бодолд нөлөөлөх, хар пиар хийх явдлууд сүүлийн үед их гарах болсон.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүн бүрийн үндсэн эрх хэдий ч түүнийг буруугаар ашиглаж, худал ташаа мэдээллийг цахим платформоор тараах нь сөрөг үр дагаварт хүргэж байна.

Худал ташаа мэдээлэл нь хүний эрхийн түгээмэл тунхаглалын суурь болсон “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” гэсэн заалтын үзэл санааг шууд зөрчиж байна. Хамарч буй хүрээгээр нь хувь хүн болон нийгэмд үзүүлж буй нөлөөллөөр ангилан авч болно.

Хувь хүн буюу иргэдийн халдашгүй байдалд:

- Бусдын зураг бичлэг хийж цахим орчинд байршуулах, тэдний халдашгүй байдалд сөргөөр нөлөөлөх, сэтгэл түгших, айх сандрах эмгэгтэй болох,
- Иргэдийн цахим хаягтаа байршуулсан зураг бичлэгийг зөвшөөрөлгүй ашиглан худал мэдээ мэдээлэл тараах, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бууруулах, найз нөхөд, хамт олон, гэр бүлээсээ хөндийрөх,

- Хувь өөртөө болон бусдад буруу эмчилгээ хийснээр цаг хугацаа алдах, эмчлэгдэх боломжоо алдах, эрүүл мэндээрээ хохирох,
- Үзэн ядсан үг хэллэг, сөрөг яриа хэрэглэж цахим орчинд хүчирхийллийг дэлгэрүүлэх,
- Худал мэдээллээс үүдэлтэй залилангийн хохирогч болох улмаар санхүүгийн хохирол учруулах,
- Стереотипууд буюу хүний нэр төрийг гутаан доромжилж нийгмийн ялгаварлал гадуурхалыг нэмэгдүүлэх,
- Сэтгэл зүйн хямралд оруулж стерссдэх, ганцаардах, улмаар амиа хорлоход хүргэх,
- Гэмт хэргийн золиос болж бие болон сэтгэлийн хохирол амсах улмаар амиа хорлох,
- Сонгох эрхэд нөлөөлж оновчтой сонголт хийж чадалгүй бусдын ятгалгад орох,

Нийгэмд буюу улс орны халдашгүй байдалд:

- Зах зээл дээр шударга өрсөлдөөн байхгүй болж бизнесийн байгууллагуудын нэр хүнд, хөрөнгийн зах зээл дээр хувьцаа нь уналтанд орж санхүүгийн хямралд орох улмаар дампуурах,

- Эрүүл мэндийн салбарт эмчилгээний талаарх ташаа мэдээлэл нь эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд саад учруулах, урьдчилан сэргийлэх боломжтой өвчин тархахад хүргэж, вакцинжуулалтын хэмжээ буурах, нийгмийн эрүүл мэндэд аюул учруулах,
- Буруу ташаа мэдээлэл нь мэргэжилтэнгүүдэд итгэх итгэлийг сулруулж нийгэмд талцал бий болгох, иргэд мэдээллийн үнэн зөвийг ялгахад саад учруулж, төөрөгдөл үүсгэх,
- Өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ хэт туйлшрах нь бусдыг уруу татаж бүлэглэж талцуулах, нийгэмд үл ойлголцол бий болж, итгэлцэл алдагдсанаар сонгуульд нөлөөлж, олон нийтийн үзэл санааг буруу тийш чиглүүлэх, улс төрийн тогтворгүй байдалд хүргэх,
- Эмх замбараагүй байдал, хүчирхийлэлтэй холбоотой үйл явдлын талаар худал мэдээлэх нь дайсагнал, түрэмгийлэл, хүчирхийллийг өдөөх,
- Улс үндэстэний итгэлцэлийг эвдэж түүх соёл, үнэт зүйлс рүү халдах, тусгаар тогтнолд нөлөөлөх,
- Үндэсний аюулгүй байдал хийгээд олон улсад үл

ойлголцолыг бий болгох зэрэг сөрөг үр дагаваруудыг бий болгож байна.

ҮР ДҮН

Хүний үндсэн эрхийг бодит болон цахим орчин аль алинд хамгаалах нь чухал асуудал болоод байна. Тэр дундаа цахим орчинд хүний үндсэн эрхийг хамгаалах нь илүү хүнд сорилтуудыг өөртөө дагуулдаг. Тиймээс хүний үндсэн эрх болох халдашгүй байдлыг хамгаалах асуудлыг технологийн хурдацтай хөгжилтэй уялдуулан шинэчилж яаралтай арга хэмжээ авч ажиллавал дижиталчлалаас үүдэлтэй хүний эрхийн зөрчигдөх асуудлуудыг урьдчилан сэргийлэх боломжтой юм. Цахим орчинд хүний эрхийг хамгаалахад тулгардаг нэг бэрхшээл нь оролцогч талуудаас үүдэлтэй байдаг. Дижитал технологийг ихэвчлэн хувь хүмүүс хөгжүүлдэг бөгөөд ямар технологийг ашиглаж юуг боловсруулж, ямар дүрэм хэрэглэж үйлчилгээ үзүүлэхийг технологийг хөгжүүлэгчид голчлон тодорхойлдог.

Харин хүний үндсэн эрх, халдашгүй байдлын талаархи ойлголт эдгээр хөгжүүлэгч нарт хомс байдаг учир цахим платформыг хөгжүүлэгч аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг хүний эрхийг хангахыг шаардах, үүрэг болгох талаар үндэсний болон олон улсын түвшинд хэлэлцэж ярих шаардлага тулгарч байна. Хүний эрхийн хамгааллын асуудал улс орнуудад

харилцан адилгүй байдаг бөгөөд зарим улс маш сайн нарийн зохицуулалт, хүчтэй хамгаалалттай байхад зарим улс хүний эрхийг хамгаалах тал дээр бус харин хязгаарлах тал дээр илүү хатуу хяналт тавих тохиолдол байдаг. Цахим орчин дахь хүний эрх, халдашгүй байдлыг олон улсад НҮБ-с баталсан Олон Улсын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг баталж гишүүн орнууд даган биелүүлэхээр зааж өгөхийн сацуу Олон Улсын Хүний Эрхийн Байгууллага болох Эмнести Интернэшнл болон бусад төрийн хийгээд төрийн бус байгууллагууд цахим ертөнцөөр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалахаар ажилладаг. Хүний эрхийг хамгаалах асуудлаар төрийн болон төрийн бус олон улсын байгууллагууд ажиллахын сацуу эрдэмтэн судлаачид технологийн дэвшилтэй холбоотойгоор цахим орчин дахь хүний эрх, халдашгүй байдлын талаар ярих болсон. Дижитал платформыг хөгжүүлэгч Роберт Б.Гелман (*Robert B. Gelman*) интернэт орчин дахь цахим мэдээлэл, хувь хүний халдашгүй байдал, мэдээллийг ашиглах, худал ташаа мэдээллүүдийг хөндсөн “Цахим орон зай дахь хүний эрхийн түгээмэл тунхаглал” хэмээх 24 зүйл бүхий тунхаглалыг боловсруулсан байдаг.

1948 онд НҮБ-н Ерөнхий Ассемблейээс баталсан ОУ-н Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19-р зүйлд хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй

илэрхийлэх эрхтэйг зааж өгөхийн сацуу 29.2-р зүйлд энэхүү эрхээ эдлэхдээ бусдын нэр, алдар хүнд, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандах үүрэгтэй талаар тусгасан байна. НҮБ-аас 1966 онд “Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт” -д хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх эрхтэйг дурдахдаа ямар тохиолдолд энэхүү эрхийг хязгаарлаж болохыг 19.3-т зааж өгчээ.

2021 оны 12 сарын 15-нд Европын Холбооны Парламентаас “Дижитал орчин дахь зах зээл үйлчилгээний талаарх хууль”-ийг батлан гаргасан ба уг хууль нь 2023 оны 8 сард дахин шинэчилж 2024 оноос Европийн Холбооны бүх цахим платформ дээр хэрэгжиж эхлээд байна. ХБНГУ нь Европийн Холбооны гишүүн орны хувьд цахим орчинд худал ташаа мэдээ мэдээлэл тараах, бусдын нэр төрд халдах, гүтгэх, доромжлох, мэдээллийн үнэн зөвийг шалгах, мэдээллийн хэрэгсэл, цахим платформ дахь асуудлыг зохицуулахаар 2017 онд “Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажиллах тухай” хуулийг батлан гаргасан байдаг. Тус хуульд фэйсбоок, инстаграмм, твиттер, ютүб болон үүнтэй төстэй цахим платформ дахь үзэн ядах, гүтгэх, доромжлох, садар самуунд сурталчлах, удал ташаа мэдээлэл тараах зэрэг цахим орчин дахь хүний халдашгүй байдлыг зөрчсөн тохиолдолд 24 цагийн дотор гомдолд хариу арга хэмжээ авах хууль бус контентэд

хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгаж өгчээ.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн Хуулийн 2-р бүлэгт МУ-д хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй хэмээн тунхаглаж МУ-н иргэдийн баталгаатай эдлэх 18 эрхийг тусгаж өгсөн байдаг. Үүний 13-г халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй гээд хэний ч нэр төрийг нь доромжилж болохгүй бөгөөд иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, халдашгүй байдлыг хуулиар хамгаална хэмээн заажээ.

2002 оны 01-р сарын 10-ны өдөр батлагдсан МУ-ийн “Иргэний хууль”-ийн 497.1-д “... нэр төр, алдар хүндэд санаатай болон хууль бусаар гэм хор учруулсан тохиолдолд” хариуцлага хүлээх тухай, 511.1-д нэр төр, алдар хүндийг гутаасан этгээдэд мөнгөн болон бусад хэлбэрээр гэм хорыг арилгах тухай тусгажээ.

2002 оны 05-р сарын 30-ны өдөр батлагдсан “Зар сурталчилгааны тухай хууль”-д мэдээллэх хэрэгсэлийг ашиглан бусдын нэр төр алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон зар сурталчилгаа явуулахыг 7.2.2-г хориглосон байдаг бол 21-р зүйлд зар сурталчилгаа түгээж буй мэдээллийн хэрэгсэлүүд мэдээллийн үнэн зөвийг баталсан нотлох баримт үзүүлэхийг шаардах эрхтэй төдийгүй үүнд төрийн захиргааны байгууллага хяналт

тавьж ажиллах талаар оруулж өгсөн байна. Үүнээс харахад цахим платформд үйл ажиллагаа явуулж буй мэдээллийн хэрэгсэлүүд мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох шаадрлагатай ба ингэснээр худал ташаа мэдээлэл тарахаас сэргийлэх боломжтой юм.

2015 оны 12 сарын 03-ны өдөр батлагдсан “Эрүүгийн хууль”-ийн 26-р бүлэгт цахим орчин дахь аюулгүй байдал болох Кибер орчинд хууль бусаар нэвтрэх болон гэмт хэрэгтнүүдийг хэрхэх тухай оруулж өгсөн байдаг. Үүнийг дагалдуулан 2017 онд “Зөрчлийн тухайн хууль” батлагдан, эрүүгийн хуулиар хүний нэр төр алдар хүндийг гутаах нь гэмт хэрэгт тооцдог байсныг Зөрчлийн хуулиар зөрчилд тооцох болсон. 2021 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 6.27.2-д “Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж, хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэж...” иргэнийг 500 нэгж, хуулийн этгээдийг 5000 нэгтжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох тухай тусгасан.

Цахим орчин дахь аюулгүй байдлын талаархи асуудлыг хүний эрхийг хамгаалагч байгууллагуудаас хөндөн гаргаж ирсэнээр МУ-ын Засгийн газар болон бүтцэд өөрчлөлт орж энэ тал дээр өөрчлөлт орж “Цахим хөгжил харилцаа холбооны яам” гэсэн нэгэн шинэ бүтэц бий болж ирсэнээр цахим орчинд дахь хувь

хүний хийгээд байгууллагын аюулгүй байдал, түүнтэй холбоотой хууль тогтоомжууд олноор батлагдаж хэрэгжиж эхэлсэн.

1995 оны 04-р сарын 21-ний өдөр “Хувь хүний нууцын тухай хууль” батлан хэрэгжүүлж байгаад, УИХ-аас 2021 оны 12-р сарын 17-ны “Хүний хувийн мэдээлэл хамгалаах тухай хууль” -ийг батлан гарсанаар өмнөх хууль хүчингүй болгосон байдаг. Тус хуулиар хувь хүний биометрик мэдээлэл, цахим платформ дахь захидал харилцаа болон бусад мэдээ мэдээллийг цуглуулах, ашиглах мэдээллийн эзний эрх үүрэг болон аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг нарийвчлан зохицуулж өгчээ. Цахим орчинд мэдээлэл хамгаалах талаарх цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн асуудлыг нарийвчлан зааж өгөхийн сацуу мэдээллийн аюулгүй байдал алдагдсан тохиолдолд албна тушаалтанг “Төрийн албаны тухай хууль”-аар, хувь хүн иргэн хийгээд байгууллагыг “Эрүүгийн хууль” болон “Зөрчлийн хууль”-аар хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна.

2021 оны 12 сарын 17-ны өдөр УИХ-с “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-ийг баталсан бөгөөд тус хуулиар цахим орчин дахь аюулгүй байдал түүнтэй холбоотой ойлголтууд болон цахим орчин дахь харилцаанд орж буй төрийн болон төрийн бус

байгууллага, иргэдийн үүргийг зааж тусгасан байна.

ДҮГНЭЛТ

Эдгээр эрх зүйн акт баримт бичгүүдээс үзэхэд МУ-д цахим орчин дахь худал ташаа мэдээ, мэдээлэл тараах, түгээх, бусдын нэр төрд халдах, гутаан дормжлох үйлдлүүдэд хүлээлгэх хариуцлага, түүнтэй холбоотой асуудлуудыг нарийвчлан хуульчилсан хэдий ч тэдгээрийн хэрэгжилтэнд анхаарал хандуулах хэрэгтэй байна. Иймээс дараах хэд хэдэн арга хэмжээг санал болгож байна. Үүнд:

1. МУ-д хүний эрх хийгээд цахим халдашгүй байдалтай холбоотой хуулиудын хоорондын уялдаа холбоо бүхий нарийвчилсан журам бүхий зохицуулалтуудыг хийх,
2. Мөн цахим орчинд дахь халдашгүй байдлыг зөрчиж, бусдад хохирол учруулахад авах шийтгэл болон түүнтэй холбоотой эрх зүйн мэдлэг мэдээллийг иргэд, цахим платформыг хөгжүүлэгчид болон байгууллага олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах,
3. ЕБС болон бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар иргэдийг цахим платформийг зүй зохистой ашиглах, өөрсдийн цахим

хуудсыг ашиглахдаа ёс зүйтэй байх, худал ташаа мэдээ мэдээлэлд цензуртэй хандаж байхыг уриалсан ажлуудыг хийх,

4. Төрийн захиргааны эрх бүхий байгууллага худал ташаа мэдээллийг шалгах, түгээн тараахаас сэргийлж технологийн дэвшлийг ашиглан, төрийн бус хүний эрхийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах,
5. Олон улсад хэрэгжиж буй дэвшилтэд технологи болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээс суралцах зэргээр нийгмийн хариуцлагын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах хэрэгцээ байсаар байна.

НОМ ЗҮЙ

1. Schopenhauer, Arthur (1945). *On the Freedom of the Will. The Philosophy of American History: The Historical Field Theory.* Translated by Morris Zucker. p.531.
2. Ho-Seoung Moon, Гёттингийн ИС Философийн салбар, “Kann der Mensch wollen, was er will?” ‘Hoheluft’ философийн сонин. 2013.08.09. <https://www.hoheluft-magazin.de/2013/08/kann-der-mensch-wollen-was-er-will/>
3. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг 1948 он. [https://www.un.org/en/about-](https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights)

- [us/universal-declaration-of-human-rights](https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights)
4. 1966 онд НҮБ-с баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт” chrome-extension://efaidnbmnnnibpcajpcgclefindmkaj/https://treaties.un.org/doc/treaties/1976/03/19760323%2006-17%20am/ch_iv_04.pdf
5. Дижитал зах зээл, үйлчилгэгэ зохицуулах хууль. 2021 он. Европын Холбооноос баталсан. <https://www.europarl.europa.eu/topics/de/article/20211209STO19124/das-gesetz-uber-digitale-markte-und-das-gesetz-uber-digitale-dienste>
6. ХБНГУ “Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажиллах тухай” хууль. 2017 он. <chrome-extension://efaidnbmnnnibpcajpcgclefindmkaj/https://www.article19.org/wp-content/uploads/2017/09/170901-Legal-Analysis-German-NetzDG-Act.pdf>
7. “Иргэний хууль”. 2002 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=299>
8. “Зар сурталчилгааны тухай хууль”. 2002 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=259>
9. “Эрүүгийн хууль”. 2015 онд шинэчлэн найруулсан <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634>
10. “Зөрчлийн тухай хууль”. 2017 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695>
11. “Хүний хувийн мэдээлэл хамгалаах тухай хууль” 2021 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>
12. “Кибер аюулгүй байдлын тухай хууль” 2021 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061>